

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2023 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2024/51/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Говьсүмбэр аймаг 2024 он	Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Сарантуяа Утас: 70543179 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: paranbayarg@audit.gov.mn Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: Баталгаат тооцоолол аудитХХК-ийн Захирал: М.Буянбулган Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com Чанарын менежер: Г.Цогтбаатар Аудитор: Н.Цэнгэнбаяр
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	14
3.5.3 Нэмэлт төсөв.....	15
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	15
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГСА	Говьсүмбэр аймаг
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлого
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

2024.08.23 № 40
танай _____ -ны № _____ -т

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР
СУМЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
О.БАЗАРБААТАР ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг багш, ажилтан албан хаагчдад олгож ирсэн боловч хууль тогтоомжид заагдаагүй үндэслэлээр тус сургуулийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/136 дугаар тушаалаар багш, ажилтан, албан хаагчдад мөнгөн шагнал олгох шийдвэр гаргаж, нийт 62 хүнд 48,038,750.00 төгрөгийг давхардуулан олгож төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх "төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах", 7.1.6 дахь "албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх", 7.1.7 дахь "албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх "утга агуулгын илэрхий алдаатай, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3

- 008020307

дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.2.1 дэх "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид, 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлж 88.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасныг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар 76.7 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>116,444,256.71</u>	<u>262,514,578.94</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,781,922.94	140,964,573.44
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,781,922.94	140,964,573.44
31211	Төрийн сангийн харилцах	1,404,126.94	130,964,573.44
31213	Нөөц харилцах ахмад	377,796.00	10,000,000.00
33	АВЛАГА	0.00	404,182.53
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	404,032.99
3351	Байгууллагаас авах авлага	0.00	149.54
35	БАРАА МАТЕРИАЛ	114,662,333.77	121,145,822.97
351	Түүхий эд материал	10,854,158.00	11,569,658.00
35110	Тусгай зориулалттай материал	10,819,158.00	11,534,658.00
35130	Эм боох материал	35,000.00	35,000.00
354	Хангамжийн материал	94,863,634.77	100,631,623.97
35410	Бичиг хэргийн материал	1,503,500.00	2,968,600.00
35420	Аж ахуйн материал	70,796,328.15	70,932,928.15
35450	Барилгын засварын материал	440,000.00	440,000.00
35460	Хүнсний материал	1,365,201.90	2,673,450.10
35470	Бусад хангамжийн материал	20,758,604.72	23,616,645.72
36	НӨӨЦИЙН БАРАА	8,944,541.00	8,944,541.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>668,005,539.78</u>	<u>6,821,475,732.19</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	668,005,539.78	6,821,475,732.19
392	Биет хөрөнгө	291,300,156.58	6,452,415,732.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	111,150,712.82	6,157,453,315.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(55,575,356.64)	(120,687,743.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	234,558,496.01	387,854,112.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(98,155,692.82)	(150,479,295.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	278,825,937.30	438,375,439.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(181,734,551.09)	(263,343,041.73)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,230,611.00	3,345,231.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(102,285.40)
393	Биет бус хөрөнгө	376,705,383.20	369,060,000.00
39301	Програм хангамж	12,939,550.00	12,939,550.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,294,166.80)	(12,939,550.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	369,060,000.00	369,060,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>784,449,796.49</u>	<u>7,083,990,311.13</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,516,213.96</u>	<u>846,950.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,516,213.96	846,950.00
413	Өглөг	2,516,213.96	846,950.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,516,213.96	0.00
4136	Бусад өглөг	0.00	846,950.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	781,933,582.53	7,083,143,361.13

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,039,022,510.65	1,039,022,510.65
	Дахин үнэлгээний нөөц	111,150,712.82	111,150,712.82
512	Хуримтлагдсан үр дүн	(368,239,640.94)	5,932,970,137.66
51210	Өмнөх үеийн үр дүн	(368,239,640.94)	(368,239,640.94)
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	6,301,209,778.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>784,449,796.49</u>	<u>7,083,990,311.13</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,810,335,220.56	8,534,249,652.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,125,634,820.56	6,319,178,652.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	14,244,300.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ	1,003,232,411.74	0.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ	117,426,908.82	6,303,664,352.55
120009	Бусад орлого	3,975,500.00	1,270,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	1,000,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	340,841,200.00	342,241,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	338,291,200.00	342,241,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,550,000.00	0.00
1330	Төсвийн захирагчдаас	1,343,859,200.00	1,872,830,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,343,859,200.00	1,872,830,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,769,130,260.59	2,233,039,873.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,769,130,260.59	2,233,039,873.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,036,579,860.06	1,332,996,182.91
210101	Үндсэн цалин	1,036,579,860.06	1,264,373,089.91
210102	Нэмэгдэл	0.00	47,634,103.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	1,780,000.00
210104	Урамшуулал	0.00	17,932,011.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	1,276,979.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,166,219.00	165,050,869.00
210201	Тэтгэврийн даатгал	89,228,398.00	115,943,026.37
210202	Тэтгэмжийн даатгал	10,497,474.00	13,631,961.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,317,329.00	10,598,505.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,920,274.00	2,281,956.48
210205	Эрүүл мэндийн даатгал	19,202,744.00	22,595,419.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	225,727,705.00	329,206,150.92
210301	Гэрэл, цахилгаан	12,309,767.00	21,274,182.52
210302	Түлш, халаалт	198,981,041.00	292,371,111.00
210303	Цэвэр, бохир ус	14,436,897.00	15,560,857.40
2104	Хангамж, бараа материалын зардал	29,459,112.95	26,692,150.00
210401	Бичиг хэрэг	427,200.00	16,568,880.00

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	610,000.00	0.00
210404	Ном, хэвлэл	3,975,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,833,900.00	10,123,270.00
210408	Бараа материал акталсны зардал	20,613,012.95	0.00
2105	Нормативт зардал	115,706,762.06	101,710,090.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,000.00	74,500.00
210502	Хоол, хүнс	115,678,762.06	101,635,590.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,973,840.00	9,019,500.00
210604	Урсгал засвар	8,973,840.00	9,019,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,156,050.00	13,620,594.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	4,244,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,156,050.00	9,376,294.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,345,747.52	228,491,595.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,820,044.00	24,406,746.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,984,350.00	992,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	120,541,353.52	203,092,849.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	22,367,892.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	22,367,892.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	59,014,964.00	3,884,849.08
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,014,964.00	3,884,849.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,041,204,959.97	6,301,209,778.60
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	272,315,918.44	0.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	272,315,918.44	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(272,315,918.44)	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	768,889,041.53	6,301,209,778.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,344,236,996.00	2,230,585,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	377,796.00	15,514,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	11,270,000.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	377,796.00	0.00
	Бусад орлого	0.00	4,244,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	342,241,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	342,241,000.00
1330	Төсвийн захирагчдаас	1,343,859,200.00	1,872,830,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,343,859,200.00	1,872,830,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,284,824,673.06	2,029,547,449.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,284,824,673.06	2,029,547,449.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	998,844,443.06	1,332,762,304.55

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	697,203,986.69	898,705,779.18
210102	Нэмэгдэл	249,116,376.36	368,755,598.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,902,185.20	18,717,398.90
210104	Урамшуулал	38,621,894.81	45,693,102.83
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	890,425.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,589,445.00	165,688,780.35
210201	Тэтгэврийн даатгал	84,936,924.64	111,184,680.35
210202	Тэтгэмжийн даатгал	9,924,726.38	13,626,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,038,641.08	10,900,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,881,932.00	2,725,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,807,220.90	27,251,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	329,206,150.92
210301	Гэрэл, цахилгаан	0.00	21,274,182.52
210302	Түлш, халаалт	0.00	292,371,111.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	15,560,857.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	9,150,000.00
210604	Урсгал засвар	0.00	9,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,169,250.00	13,762,694.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	4,244,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,169,250.00	9,518,394.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,955,590.00	47,264,576.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,678,990.00	30,059,396.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,276,600.00	17,205,180.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,265,945.00	127,828,094.60
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	114,265,945.00	105,460,202.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	22,367,892.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	3,884,849.08
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	3,884,849.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>59,412,322.94</u>	<u>201,037,850.50</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	57,630,400.00	61,855,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	57,630,400.00	61,855,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>1,781,922.94</u>	<u>139,182,650.50</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,781,922.94	139,182,650.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,781,922.94
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,781,922.94	140,964,573.44

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,039,022,510.65	111,150,712.82	(368,239,640.94)	781,933,582.53
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,039,022,510.65	111,150,712.82	(368,239,640.94)	781,933,582.53
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,039,022,510.65	111,150,712.82	(368,239,640.94)	781,933,582.53
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	6,301,209,778.60	6,301,209,778.60
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,039,022,510.65	111,150,712.82	5,932,970,137.66	7,083,143,361.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		1,404,126.94	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,883,052,000.00	1,748,783,853.50	92.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,739,100,100.00	1,620,955,758.90	93.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,432,979,900.00	1,332,762,304.55	93.0
210101	Үндсэн цалин	974,339,400.00	898,705,779.18	92.2
210102	Нэмэгдэл	403,889,800.00	368,755,598.64	91.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт		18,717,398.90	
210104	Урамшуулал	54,750,700.00	45,693,102.83	83.5
210105	Гэрээт ажлын хөлс		890,425.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,122,700.00	165,688,780.35	92.5
210201	Тэтгэврийн даатгал	121,803,500.00	111,184,680.35	91.3
210202	Тэтгэмжийн даатгал	14,329,800.00	13,626,100.00	95.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,463,800.00	10,900,900.00	95.1
210204	Ажилгүйдлийн даатгал	2,866,000.00	2,725,300.00	95.1
210205	Эрүүл мэндийн даатгал	28,659,600.00	27,251,800.00	95.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	19,619,200.00	15,708,394.00	80.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,148,500.00	4,244,300.00	52.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,470,700.00	11,464,094.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	107,378,300.00	106,796,280.00	99.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,172,200.00	89,591,100.00	99.4

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,206,100.00	17,205,180.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143,951,900.00	127,828,094.60	88.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	121,584,000.00	105,460,202.60	86.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,367,900.00	22,367,892.00	100.0
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,883,052,000.00	1,878,344,300.00	99.7
12000	Нийтлэг татварын бус орлого	8,818,500.00	5,514,300.00	62.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	8,148,500.00	4,244,300.00	52.1
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	670,000.00	1,270,000.00	189.6
1330	Төсвийн захирагчдаас	1,874,233,500.00	1,872,830,000.00	99.9
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,874,233,500.00	1,872,830,000.00	99.9

Аудит хийсэн Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	342,241,000.00	338,356,150.92	98.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	342,241,000.00	338,356,150.92	98.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	333,091,000.00	329,206,150.92	98.83
210301	Гэрэл, цахилгаан	22,500,000.00	21,274,182.52	94.55
210302	Түлш, халаалт	292,681,000.00	292,371,111.00	99.89
210303	Цэвэр, бохир ус	17,910,000.00	15,560,857.40	86.88
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,150,000.00	9,150,000.00	100.00
210604	Урсгал засвар	9,150,000.00	9,150,000.00	100.00
12200	Тусламжийн орлого	342,241,000.00	342,241,000.00	100.00
122005	Төсвөөс санхүүжих	342,241,000.00	342,241,000.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Тайлант онд нэмэлт санхүүжилт хийгдээгүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2 дугаар сургууль нь Боловсролын ерөнхий хуульд тодорхойлсноор хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино гэж тодорхойлсон. Энэ хүрээнд сургуулийн менежментийг сайжруулах, багш сурагчдын хөгжил, сурлагын чанарт ахиц гаргах зорилго, үндсэн чиг үүрэг бүхий аймгийн Боловсролын газрын харьяа байгууллага юм.

Тайлант онд жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлж 88.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасныг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар 76.7 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сүмбэр сумын 2 дугаар сургууль нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Боловсролын тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол ;
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тус байгууллага дотоод хяналтын чиг үүргийг газрын даргын тушаалаар батлагдсан журам зааврыг мөрдлөг болгодог. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг засаж, зөвлөмжийг биелүүлэн ажилласан тул байгууллагын дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар түүнийг аудитад ашиглахгүй гэж үзлээ.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны хувьд Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль болон бусад хуулиудад нийцүүлэн гарсан дээд шатны байгууллагуудын тогтоол, журам, тушаал, шийдвэрүүдийг өөрийн үйл ажиллагаандаа эрхлэгчийн тушаалаар тухай бүрт нь өөрчлөлт оруулан мөрдлөг болгон ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль аймгийн хэмжээнд нийтлэг мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг ба зарим нэг хууль тогтоомжийн өөрчлөлтийг эс тооцвол нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,299,540.5 мянган төгрөгөөр буюу 7.9 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,781.9	140,964.6	139,182.7
Бараа материал	114,662.3	121,145.8	6,483.5
Авлага	0.0	404.2	404.2

Үндсэн хөрөнгө	668,005.6	6,821,475.7	6,153,470.1
Нийт хөрөнгө	784,449.8	7,083,990.3	6,299,540.5
Өглөг	2,516.2	846.9	-1,669.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	781,933.6	7,083,143.4	6,301,209.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	784,449.8	7,083,990.3	6,299,540.5

Дээрх хүснэгтээс харахад, дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 139,182.7 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн сангаас санхүүжилт орж ирсэн, орон тоо дутуу ажиллаж үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 6,483.5 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй бараа материалын дүнтэй холбоотой;
- Авлага өмнөх оноос өссөн нь ажиллагсаас 404.2 мянган төгрөгийн авах авлага үүссэнтэй холбоотой;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 6,153,470.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд сургуулийн шинэ барилга, уурын зуухны өргөтгөлийг үндсэн хөрөнгөд бүртгэлд авсантай холбоотой;
- Өглөг 1,669.3 мянган төгрөгөөр өглөг буурсан байна.
- Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 203,406.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд хүлээн авсан үндсэн хөрөнгө нөлөөлсөн;

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,483,364.0 мянган, орон нутгийн төсвөөс 342,241.0 мянган, нийт зарлагыг 1,825,605.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс 101,885.4 мянган төгрөгөөр зардлыг бууруулж 1,723,719.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн хэмнэлтийн хууль болон бусад хуулиудад өөрчлөлт орсон, төсвийн тооцооллыг үндэслэлтэй хянаагүйтэй холбоотой.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн тодотголоор улсын төсвийг 501,573.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,883,052.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийг 342, 241.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,872,830.0 мянга, орон нутгийн төсвөөс 342,241.0 мянга, үйл ажиллагааны орлогын 5,514.3 мянга нийт 2,220,585.3 мянган төгрөгийн санхүүжилтийг үйл ажиллагаандаа зарцуулж, улсын төсвийн данснаас төвлөрүүлэх шилжүүлэг хийгээгүй ба орон нутгийн төсвийн санхүүжилтээс 3,884.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Харилцах данс 140,964.6 мянган төгрөг үлдэгдэлтэй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилт олгоогүй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийн хүрээнд 135,192.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч орлогоор бүртгэсэн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүмбэр сумын 2 дугаар сургууль 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, чанарын менежер Г.Цогтбаатар нар гүйцэтгэж, хяналтыг захирал М.Буянбулган болон Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар хэрэгжүүлсэн.

Сүмбэр сумын 2 дугаар сургууль 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,769,130.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 17,691.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Учир нь 2023 онд зарим эрх зүйн актуудад өөрчлөлт орсонтой холбоотой. Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,233,039.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож, материаллаг байдлыг 22,330.4 мянган төгрөгөөр тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай 32 заалтын хэрэгжилтэд аудитын горим, сорил гүйцэтгэхээр төлөвлөж, хяналтыг хэрэгжүүлэв. Байгууллага төсвийн үргүй зардал гаргахгүй байх, батлагдсан төсвийг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Хуулийн хүрээнд төсвийн хэмнэлтийг авч үзэхэд нийт урсгал зардал 121,743.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна. Үүнд:Цалин хөлс, болон нэмэгдэл урамшуулал

88,545.2 мянган болон ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл 9,208.6 мянга, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 2,710.3 мянга, Бараа үйлчилгээний бусад зардал 3,320.0 мянга, Бусад урсгал шилжүүлэг 24,599.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь нөлөөлжээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 11 тушаал орхигдуулсан ба бүх тушаалыг мөнгөн дүнгээр бус хувиар илэрхийлсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журмын 3 дугаар зүйлийн 3.2.10-тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн мэдээлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Үндэсний аудитын газраас зарласан сонгон шалгаруулалтаар Говьсүмбэр аймгийн багц 1-д тэнцэж, гурвалсан гэрээг 2023 оны 10 дугаар сарын 13-нд байгуулж, аудитын нээлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай шалгагдагч байгууллагуудын удирдлага, нягтлан бодогчдыг оролцуулан хийв. Завсрын аудитыг эхний 9 сарын санхүүгийн болон холбогдох баримт, байгууллагын үйл ажиллагаатай биечлэн танилцах ажилбаруудыг гүйцэтгэж, илэрсэн алдаа, зөрчлийн асуудлыг байгууллагын удирдлагад танилцуулж, уулзалтын тэмдэглэлээр баримтжуулсан.

Асуудлын бүртгэлийг жилийн дүнгээр нэгтгэн танилцуулж шийдвэрлүүлэхээр тогтсон болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон албан шаардлагын хэрэгжилтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 онд танилцуулга бэлтгэж цахимаар хүргүүлсэн байв.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	1,571,935.1	1	1,571,935.1	100.0
Зөвлөмж	2	9,110.0	2	9,110.0	100.0
Нийт дүн	3	1,581,045.1	3	1,581,045.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн хэмжээнд нийтлэг мөрддөг Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигтэй ба энэ байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгасан эсэх, захирлын гаргасан зарим тушаалын заалт Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын холбогдох тушаалын заалттай нийцүүлээгүй, гүйцэтгэлийн талаар тодорхой тусгахгүй байгаад анхаарах

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 61,355.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн бөгөөд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 2 зөвлөмж, 1 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв өгөв.

5.1 Төлбөрийн акт

1. Урамшуулалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр олгосон боловч сургуулийн захирлын 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн Б/33 дугаар тушаалаар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Зөрчилгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр нягтлан бодогч С.Ганганнавчид сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээний буюу 1,292,235.00 төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 40.3 дэх "Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ", Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх "Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна." Сангийн сайдын 2022 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 25 дахь заалтыг тус тус зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Давхардуулан олгосон урамшууллыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх

5.2 Албан шаардлага

5.3 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

Аймгийн хэмжээнд нийтлэг мөрддөг Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигтэй ба байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгаагүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нөлөөлөх магадлалтай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9 дэх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18.2 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" тус тус зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг холбогдох хууль, журам, өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусган мөрдөх

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

Бараа материалын тайлан, анхан шатны баримтуудтай танилцахад агуулахын бүртгэл хөтөлдөггүй, зарим баримтын гарын үсгийн баталгаажуулалт дутуу, шинээр карталсан хөрөнгийг тухай бүрт кодлоогүй байсан нь холбогдох журмын зааврыг бүрэн мөрдлөг болгож хэвшүүлээгүйтэй холбоотой.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан журмын тухайн маягтуудыг хөтлөх, гүйцэтгэлд хяналт тавих зааврыг мөрдлөг болгоогүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Агуулахын бүртгэл болон бусад анхан шатны баримтыг холбогдох журам зааврын дагуу бүрэн хөтөлж, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах

3. Нэмэгдэл цалинтай холбоотой

Илрүүлэлт:

Хууль тогтоомжийн хэрэглээний ойлголтын зөрүүгээр Хөдөлмөрийн гэрээг алдаатай байгуулснаас Өндөр насны тэтгэвэрт гарсан хавсралт дахь нэр бүхий 12 ажилтан 2023 онд 4-12 сарын хугацаанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд 11,225,545.00, ур чадварын нэмэгдэлд 1,159,631.00 нийт 12,405,176.00 төгрөг тооцогдсоноос нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ын суутгалыг тооцож, 12,024,211.00 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйл. Хориглох зүйлийн 31.1.4-т "хууль тогтоомжид заасан бусад тохиолдолд", Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар зөвлөмжийн 8-д "Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн" эсхүл "төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн" үндэслэлээр чөлөөлөгдсөн хүнийг төрийн албаны сонгогддогоос бусад үндсэн албан тушаалд томилон ажиллуулж болохгүй. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнийг төрийн байгууллага зөвхөн гэрээний үндсэн дээр, төрийн албан хаагчийн эрх зүйн байдалгүйгээр тодорхой хугацаанд ажил үүрэг гүйцэтгүүлж болно" заалтуудыг

мөрдлөг болгоогүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн гэрээг холбогдох эрх зүйн актуудыг сайтар судалж, түүнд нийцүүлэн байгуулах, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах

5.4.1 Захирлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/136 дугаар тушаалаар 61 багш, ажилтан, албан хаагчдад нийт 48,038,750.00 төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн сангаас олгосон.

Энэ нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх “ төсвийн болон хандив тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах”, 7.1.6 дахь “албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх” 7.1.7 дахь “албан тушаалын байдлаа ашиглан ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх “утга агуулгын илэрхий алдаатай, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.2.1 дэх "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид, 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.” гэсэн заалтыг тус тус зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Эрх мэдлээ хэтрүүлэн цалингийн сангаас хавтгайруулан олгосон мөнгөн урамшууллыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн		
Шагналт цалин олгосон	1	48,038.8			-	-	-	-	-	-			1	48,038.8
Урамшуулал давхардуулан олгосон	1	1,292.2	1	1,292.2										
НББ-тэй холбоотой	1	0.0					1	0.0						
Дүн	3	49,331.0	1	1,292.2	-	-	1	0.0	-	-	-	-	1	48,038.8

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн данстай холбоотой	1	0.0	-	-	1	0.0	-	-
Анхан шатны баримттай холбоотой	1	0.0	-	-	-	-	1	0.0
Нэмэгдэл цалинтай холбоотой	1	0.0	-	-	-	-	1	0.0
Дүн	3	0.0	-	-	1	0.0	2	0.0

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР